

## **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

### **“Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал**

**Огноо:** 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Цаг: 15:00 -17:34

**Хурлын хэлбэр:** Цахимаар

**Хурлын дарга:** Ломбын Эрхэмбаяр

**Хурлын нарийн бичгийн дарга:** Болдбаатарын Нямбаяр

**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо:** 96

**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо:** 168,536,041 ширхэг.

**Хурлын ирц:** 84,27%

#### **Тусгай тэмдэглэл:**

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг “Түмэн шувуут” Хувьцаат компанийн цахим хуудсаар дамжуулан шууд хийх болсон тухай танилцуулав. Мөн хуралд оролцогсдын оролцоог хангах үүднээс зүүм программаар орох боломжийг нээж өгсөн ба хуралд оролцохоор цахимаар бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн гар утсанд 2021 оны 04-р сарын 21-ны өглөө 09:00 цагаас эхлэн нэвтрэх код хаягийг санал өгөх кодын хамт илгээсэн болно. Бүртгэлийг цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар бүртгэсэн.

Хурлын дарга хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж хурлаар хэлэлцэх асуудал нэг бүрийг хэлэлцсэний дараагаар санал асуух, санал хэлэх, шүүмж хэлэхээр шийдвэрлэв.

### **ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ**

**1 дэх асуудал:** “Түмэн шувуут” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах;

**2 дахь асуудал:** Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх Мэдээллийг энэ жил ТУЗ-ийн гишүүд хийхээр төлөвлөсөн бөгөөд тус бүр Зүүм программаар оролцож хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэхээр болсон.

ТУЗ-ийн хараат бус гишүүн: Ц.Наран-Учрал- Компанийн 2020 оны санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах

ТУЗ-ийн хараат бус гишүүн: А.Бакей- Байгууллагын хүний нөөц болон цалин урамшууллын асуудал

ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Мөнх-Очир: Хувьцааны үн ханш, хөрөнгө оруулагчдад нээлттэй хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг тус тус хийхээр болсныг танилцууллаа.

**3 дахь асуудал:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

**4 дэх асуудал:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

## ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

### 1 дэх асуудал:

#### 1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ж.Болд

“Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд 2020 онд хийж гүйцэтгэсэн ажлууд, оны онцлох үйл явдлууд, тухайн оны санхүүгийн тайлан болон цаашид хийхээр төлөвлөж байгаа зорилтуудынхаа тухай дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ танилцуулав. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай Төлөөлөн Удирдах Зөвлөл хурлаараа хэлэлцээд дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ц.Наран-Учрал нийт хувьцаа эзэмшигчдэд уншиж сонордуулав.

Тусгай тэмдэглэл:

#### Өндөгний үнэ яагаад өсөөд байна вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Цар тахлын нөлөө дэлхий дахинд харилцан адилгүй байдлаар нөлөөлж байна. Бид тэжээлийн түүхий эдээ ОХУ-аас импортлон авдаг. Түүхий эдийн үнэ гадаад зах зээл дээр өссөн, хил хаагдсанаас үүдэлтэй олдоц багатай байсан нь өндөгний үнэ нэмэгдэхэд нөлөөлсөн. Бид 2021 онд энэ эрсдлээс сэргийлж түүхий эдийн нөөц бүрдүүлэх зэрэг хэд хэдэн арга хэмжээг авч ажиллаж байна.

#### Хувьцааны ногдол ашгаа хэзээ өгөх вэ?

ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр: Хувьцаа эзэмшигч та хувьцааны ногдол ашгаа 2021 оны 05-р сарын 12-ны өдрөөс эхлээд ҮЦТХТ-өөр дамжуулан өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компанитай холбогдож авна. 2020 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 8 төгрөгийг олгохоор ТУЗ-ийн хурлаас шийдвэрлэсэн.

#### 2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Түмэн шувуут” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлав.

#### 3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

| Зөвшөөрсөн                  |                                        | Татгалзсан                  |                                        | Түдгэлзсэн                  |                                        |
|-----------------------------|----------------------------------------|-----------------------------|----------------------------------------|-----------------------------|----------------------------------------|
| Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа | Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа | Нийт саналын эрхтэй хувьцаа | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа |
| 200,000,000                 | 168,539,041                            | 200,000,000                 | 168,539,041                            | 200,000,000                 | 168,539,041                            |
| Тоо                         | Хувь                                   | Тоо                         | Хувь                                   | Тоо                         | Хувь                                   |
| 161,83,887                  | 99,98%                                 | 961                         | 0,01%                                  | 0                           | 0%                                     |

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,98% зөвшөөрөв.

## **2 дахь асуудал:**

### **Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх:**

**Танилцуулсан нь:** Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: “Түмэн шувуут” ХК-ийн Алсын хараа ба бизнесийн боломжууд сэдвээр мэдээлэл хийв. Агуулга нь Махны хонь үржүүлэх кластар төслийн талаарх бизнесийн боломжуудыг тооцоо судалгаатай танилцууллаа.

**Тусгай тэмдэглэл:** ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Бакей- Түмэн шувуут ХК-ийн хэмжээнд баримталж байгаа цалин урамшуулал, хүний нөөцийн бодлогын талаар мэдээлэл өгөхдөө: Тус компанийн хүний нөөцийн сүүлийн 4-5 жилийн хугацааны цалингийн судалгааны үзүүлэлтээс харахад хүний нөөцийг компанийн үнэт капитал гэдэг талаас нь харж, ажилтнуудынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалт хийн, бүтээмж нэмэгдүүлэх байдлаар, ашиг орлого олох талаар баримт судалгаатай тайлбар хийв.

Мөн Хараат бус гишүүн Г.Мөнх-эрдэнэ - Хувьцаа эзэмшигчдэд зориулсан хувьцааны үн ханш, ач холбогдол, Түмэн шувуут ХК-ийн засаглалын нээлттэй ил тод байдлын талаарх мэдээлэл бэлтгэж нийт хувьцаа эзэмшигчдэд танилцууллаа.

2. Энэ асуудлаар ямар нэгэн шийдвэр гараагүй бөгөөд санал хураагаагүй болно.

## **3 дахь асуудал**

### **1. Хэлэлцсэн нь:**

Танилцуулсан нь : Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн мэдээллийг танилцуулж хэлэлцэв.

Танилцуулгын гол агуулга: Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүнийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Мөн цахимаар хэрхэн саналаа өгөх зөвлөмжийг өгөв. Энэ зөвлөмж дээр шинээр журамд орсон өөрчлөлтийг мөн тусгаж заавар өгсөн болно.

### **2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:**

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгов:

1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Ломбо овогтой Эрхэмбаяр
- 1.1.2. Балай овогтой Тунгалаг
- 1.1.3. Жигжид овогтой Болд
- 1.1.4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал
- 1.1.5. Эрдэнэчулуун овогтой Жаргалхүү
- 1.1.6. Болд овогтой Өлзийбаяр

1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. Цэдэв овогтой Наран-Учрал
- 1.2.2. Агипар овогтой Бакей
- 1.2.3. Гочоо овогтой Мөнх-Эрдэнэ

2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгов.
3. ТУЗ-ын бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэгч /Б.Нямбаяр/-д үүрэг болгов.

### 3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

| Зөвшөөрсөн                                 |                                                       | Татгалзсан                                 |                                                       | Түдгэлзсэн                                 |                                                       |
|--------------------------------------------|-------------------------------------------------------|--------------------------------------------|-------------------------------------------------------|--------------------------------------------|-------------------------------------------------------|
| Нийт саналын эрхтэй хувьцаа<br>200,000,000 | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа<br>168,536,041 | Нийт саналын эрхтэй хувьцаа<br>200,000,000 | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа<br>168,536,041 | Нийт саналын эрхтэй хувьцаа<br>200,000,000 | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа<br>168,536,041 |
| Тоо                                        | Хувь                                                  | Тоо                                        | Хувь                                                  | Тоо                                        | Хувь                                                  |
| 161,827,387                                | 99,98%                                                | 4000                                       | 0,01%                                                 | 461                                        | 0,01%                                                 |

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

| Овог нэр               | Санал өгсөн эрх | Саналын хувь |
|------------------------|-----------------|--------------|
| Ломбо Эрхэмбаяр        | 149,135,417     | 10.24%       |
| Балай Тунгалаг         | 147,528,758     | 10.13%       |
| Жигжид Болд            | 148,361,582     | 10.19%       |
| Эрхэмбаяр Баяржаргал   | 281,262,486     | 19.31%       |
| Эрдэнэчулуун Жаргалхүү | 146,181,323     | 10.04%       |
| Болд Өлзийбаяр         | 146,030,962     | 10.03%       |

Үүнээс: Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Б.Баяржаргал, Э.Жаргалхүү, Б.Өлзийбаяр нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

| Овог нэр          | Санал өгсөн эрх | Саналын хувь |
|-------------------|-----------------|--------------|
| Цэдэв Наран-Учрал | 145,955,827     | 10.02%       |
| Агипар Бакей      | 145,943,826     | 10.02%       |
| Гочоо Мөнх-Эрдэнэ | 146,086,404     | 10.03%       |

Үүнээс Ц.Наран-Учрал, А.Бакей, Г.Мөнх-Эрдэнэ нар сонгогдов.

### 4 дахь асуудал:

#### 1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Л.Эрхэмбаяр

Танилцуулгын гол агуулга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай хэлэлцэв.

#### 2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлав. (*Хавсралтаар: Ердийн болон хараат бус гишүүдийн цалинг хуралд оролцсон байдлаар тооцох ба ТУЗ-ийн 1 удаагийн хуралд оролцоход гишүүн тус бүр 500,000 төгрөгийн цалин авахаар батлав.* )
2. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.

### 3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

| Зөвшөөрсөн                                 |                                                       | Татгалзсан                                 |                                                       | Түдгэлзсэн                                 |                                                       |
|--------------------------------------------|-------------------------------------------------------|--------------------------------------------|-------------------------------------------------------|--------------------------------------------|-------------------------------------------------------|
| Нийт саналын эрхтэй хувьцаа<br>200,000,000 | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа<br>168,536,041 | Нийт саналын эрхтэй хувьцаа<br>200,000,000 | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа<br>168,536,041 | Нийт саналын эрхтэй хувьцаа<br>200,000,000 | Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа<br>168,536,041 |
| Тоо                                        | Хувь                                                  | Тоо                                        | Хувь                                                  | Тоо                                        | Хувь                                                  |
| 161,827,156                                | 99,98%                                                | 1192                                       | 0,01%                                                 | 3500                                       | 0,01%                                                 |

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,98% нь зөвшөөрч, 0,01% нь татгалзаж, 0,01% нь түдгэлзэв.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцууллаа.

Хурлын дарга Л.Эрхэмбаяр Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 17:34 цагт хурал өндөрлөв.

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА  Л.ЭРХЭМБАЯР  
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  Б.НЯМБАЯР